

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө болон албаны даргын 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр баталсан 29/01 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1. Аудитын зорилго:

Сумдын ЗДТГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх.

2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна. Мөн Төрийн аудитаас санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж дүгнэлт өгөгдсөн тул санхүүгийн тайлагналын хэсгийг хамруулахгүй.

Илэрсэн асуудал	Зөвлөмж
1.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй	<ol style="list-style-type: none"> 1. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох 2. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх 3. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах 4. Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх

	<ol style="list-style-type: none"> 5. Тухайн эрсдэлийг бууруулах, хүлээн зөвшөөрсөн түвшинд хүртэл удирдах байдлаар төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах 6. Эрсдэлийн удирдлагыг гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгэн хэсэг болгон тайлагнах 7. Удирдлагыг эрсдэлийн удирдлагын мэдээллээр хангах 8. Нэгээс доошгүй албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах 9. Жил бүр давтагдан гарч байгаа төсөв, санхүүтэй холбоотой эрсдэлд дүн шинжилгээ хийж, залилан байгаа эсэхийг тодорхойлох 10. Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх
<p>2. Эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй</p>	<ol style="list-style-type: none"> 1. Дотоод хяналтын нэгжийн журмаа өөрийн байгууллагын онцлогт тохируулан шинэчлэх 2. Журмандаа дотоод хяналтын нэгжид ажлыг сайжруулах талаар тусгаж, ажлыг үнэлэн, биелэлтийг тооцон хууль тогтоомжид нийцсэн урамшууллын хөшүүргийг тусгаж өгөх 3. Дотоод хяналтын нэгжийн албан хаагчийг холбогдох мэргэшүүлэх байгууллагын сургалтад хамруулж мэргэшүүлэх 4. Дотоод хяналтын нэгжийн ажлын төлөвлөгөөнд цалингийн санд хийх хяналтыг тогтмолжуулах 5. Дотоод хяналтын нэгжийн жилийн төлөвлөгөөг эрсдэлд суурилан төлөвлөх 6. Дотоод хяналтын зураглалтай болох, түүнийг хамт олноороо мөрддөг байх
<p>3. Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшил олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр үр дүнгийн урамшил олгосон.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Захирамж, тушаал шийдвэрийн үндэслэлийг хуулийн дагуу төлөвлөх 2. Хууль эрх зүйн ажилтаны ажлын хариуцлагыг дээшлүүлэх 3. Байгууллагын дотоод хяналтын нэгж цалин хөлс олголтод хяналт тавихдаа холбогдох захирамж, тушаалын үндэслэлийг хянах 4. Удаа дараа зөрчил гаргаж байгаа нягтлан бодогчид хариуцлага тооцон, ажлыг нь сайжруулах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх 5. Нягтлан бодогч нь ажлын байрандаа суралцах, мэдлэг мэдээллээ дээшлүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх

<p>4. Тооцооллын алдаа гаргаж 6 дугаар сард нэг албан хаагчаас 20 хувиар илүү суутгал хийсэн</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нягтлан бодогч гүйлгээ хийх тухай бүрд, цалин хөлс бодохдоо цагийн баланс, холбогдох тушаал шийдвэртэй сар бүр тулган шалгах, өөрөө өөрийгөө давтан хянах хяналтыг тогтмол хийж байх 2. Байгууллагын удирдлага хяналтыг хийхдээ холбогдох баримтуудтай нэг бүрчлэн тулган баталгаажуулж байх
<p>5.Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тооцоо нийлсэн актыг үйлдэж хэвшээгүй</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдолтой хууль, журам, заавартай сайтар танилцаж судлах 2. Харилцагч иргэн, аж ахуй нэгжтэй тооцоо нийлсэн актыг бүрэн үйлдэж байх 3. Өр авлагаа баталгаажуулж ажиллах 4. Мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөөг тогтмол авч ажиллах
<p>6. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан</p>	<ol style="list-style-type: none"> 1. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх 2. Төсвийн хөрөнгөөс зохих зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулж байгааг таслан зогсоох 3. Төрийн хяналт шалгалтын байгууллагуудын өгсөн үүрэг даалгаварыг эргэн харж биелэлтийг хангуулах ажлыг байгууллага дотроо зохион байгуулах 4. Нягтлан бодогчийн ажиллах чадварыг нэмэгдүүлэх талаар үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцон ажиллах
<p>7. Анхан шатны баримт болон и-баримтгүй гүйлгээ хийсэн, шатахууны тайлан гаргаагүй, шаардах хуудас болон шатахууны зарлагын дүнгүүд хоорондоо зөрүүтэй</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримтын бүрдэл дутуу болон и-баримтгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэж байгааг таслан зогсоох, төлбөрийн баримтыг бүрэн гүйцэд бүрдсэний дараа ажил гүйлгээг бүртгэж байх. 2. Сар бүр нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах 3. Санхүүгийн баримтуудыг үдэхдээ анхан шатны баримтуудыг бүрэн гүйцэд хавсарган, эмх цэгцтэй үдэж байх, үүнд дотоод хяналтын нэгж, байгууллагын удирдлага хяналт тавьж ажиллах 4. Захирамж болон тушаал шийдвэрээр хөрөнгө зарцуулахдаа хавсралтад шагнал, бэлэг авсан хүнээр гарын үсгийг зуруулах, зарлагын баримт болон и-баримтыг бүрэн хавсаргаж хэвших. 5. Шатахууны тооцоог бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай сар бүр хийж байх

	<ol style="list-style-type: none"> 6. Няrvын гаргасан бараа материалын тайланг сар бүр нягтлан бодогч шалгаж хүлээн авч хэвших 7. Бараа материалын тайланг нэр төрал тус бүрээр, улирал, хагас, бүтэн жилээр гаргуулан шалгаж хүлээн авч байх 8. Жолоочийн замын хуудсыг тогтмол бичүүлж, тооцоог сар бүр бодож хэвших
<p>8. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллаагүй</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн аудитын байгууллага болон СХДАА-аас хийгдэж байгаа шалгалт бүрээр эрсдэлтэй үнэлэгдэж байгаад дүгнэлт хийж ажиллах 2. Санхүүгийн тайлагналд зөрчилтэй дүгнэлт авч байгааг анхаарч, дахин ийм зөрчлийг гаргахгүй байхаар ажлаа өдөр, сараар төлөвлөн ажиллах 3. Жилийн явц дунд Төрийн аудит, Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд хүсэлт уламжлан санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг хянуулах, заавар зөвлөгөө авах зэргээр илэрч байгаа зөрчлөө бууруулах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан баталж, мөрдөж ажиллах